| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **196,432,600.00** | **56,954,192.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 196,432,600.00 | 56,954,192.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 168,860,400.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 27,572,200.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 56,954,192.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(196,432,600.00)** | **(56,954,192.00)** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | 205,036,000.00 | - |
| 145007 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 205,036,000.00 | - |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 205,036,000.00 | - |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 205,036,000.00 | - |
| **24** | **ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР** | - | - |
| **25** | **Санхүүгийн үйл ажиллагааны зардал** | **12,721,142.72** | **55,771,622.25** |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүү | 12,721,142.72 | 55,771,622.25 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(12,721,142.72)** | (55,771,622.25) |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 136,233,720.80 | 384,814,364.04 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **362,368,760.13** | **498,602,480.09** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **498,602,480.93** | **883,416,844.97** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **2,901,979,135.03** | **4,474,591,190.43** | **(1,208,244,292.56)** | - | **6,168,326,032.90** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 10,386,065.00 | - | 10,386,065.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,901,979,135.03** | **4,474,591,190.43** | **(1,197,858,227.56)** | - | **6,178,712,097.90** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | 31,726,020.40 | - | - | 31,726,020.40 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 947,857,090.05 | - | 947,857,090.05 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,901,979,135.03** | **4,506,317,210.83** | **(250,001,137.51)** | - | **7,158,295,208.35** |
| D01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **2,901,979,135.03** | **4,506,317,210.83** | **(250,001,137.51)** | - | **7,158,295,208.35** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,901,979,135.03** | **4,506,317,210.83** | **(250,001,137.51)** | - | **7,158,295,208.35** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 633,040,760.42 | - | 633,040,760.42 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,901,979,135.03** | **4,506,317,210.83** | **393,996,519.29** | - | **7,802,292,865.15** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,096,322,658.00** | **4,253,631,881.84** | **157,309,223.84** | **103.8** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **4,096,322,658.00** | **4,253,631,881.84** | **157,309,223.84** | **103.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **4,096,322,658.00** | **4,139,193,216.15** | **42,870,558.15** | **101.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,701,322,658.00** | **4,126,779,061.42** | **425,456,403.42** | **111.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл суутгал** | **1,292,696,240.00** | **1,591,746,081.19** | **299,049,841.19** | **123** |
| 210101 | Үндсэн цалин | 1,292,696,240.00 | 1,591,746,081.19 | **299,049,841.19** | **123** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **161,587,030.00** | **431,559,908.89** | **269,972,878.89** | **267.1** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 431,559,908.89 | 431,559,908.89 | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **86,059,761.38** | **119,051,882.52** | **32,992,121.14** | **138.3** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,936,625,12 | 30,548,583.35 | 13,611,958.23 | 180.4 |
| 210302 | Түлш, халаалт | 58,042,141.26 | 64,445,372.49 | 6,403,231.23 | 111.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,080,995.00 | 24,057,926.68 | **12,976,931.68** | **217.1** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **46,629,168.00** | **118,541,949.62** | **71,912,781.62** | **254.2** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,109,221.00 | 56,859,321.00 | 47,750,100.00 | 624.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,372,230.00 | 20,033,038.00 | 10,660,808 | 213.7 |
| 210403 | Шуудан,холбоо, интернетийн төлбөр | 11,080,995.00 | 7,282,919.62 | (3,798,075.38) | 65.7 |
| 210404 | Ном, хэвлэл | 800,000.00 | 380,050.00 | 419,950.00 | 47.5 |
| 210405 | Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал | 978,450.00 | 1,350,000.00 | 371,550.00 | 138.0 |
| 210406 | Сантехникийн материал, засвар | 11,034,525.00 | - | -- | |
| 210407 | Цахилгааны материал засвар | 978,450.00 | - | - | - |
| 210408 | Цэвэрлэгээний материал | 691,295.00 | - | - | - |
| 210409 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс | 2,058,600.00 | 32,636,621.00 | 30,578,021.00 | 1,585.4 |
| **2105** | **Нормативт зардал** | **525,402.00** | **14,224,885.00** | **13,699,483.00** | **2,707.4** |
| 210501 | Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 788,550.00 | - | - |
| 210502 | Хоол хүнс | - | 11,907,335.00 | - | - |
| 210503 | Нормын хувцас, нормын цай сүү | 525,402.00 | 1,529,000.00 | 1,003,598.00 | 2,910.1 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,667,135.00** | **154,621,342.00** | **138,954,207.00** | **986.9** |
| 210601 | Багаж,техник хэрэгслийн засвар | 689,315.00 | 50,003,670.00 | 49,314,355.00 | 7,254.1 |
| 210602 | Тээврийн хэрэгслийн засвар сэлбэг | 11,034,525.00 | - | - | - |
| 210603 | Туслах үйл ажиллагааны зардал | 3,252,000.00 | - | - | - |
| 210604 | Барилгын засвар материал | 691,295.00 | 104,617,672.00 | 103,926,377.00 | 1,513.4 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **224,579,661.00** | **442,418,838.03** | **217,839,177.03** | **197.0** |
| 210701 | Гадаад албан томилолт | 200,000,000.00 | 320,664,278.48 | 120,664,278.48 | 160.3 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,579,661.00 | 121,754,559.55 | 105,174,898.55 | 734.4 |
| 210703 | Гадаад арга хэмжээ | 8,000,000.00 | - | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **998,397,590.00** | **1,188,902,764.17** | **190,505,174.17** | **119.1** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | - | 1,161,642,175.36 | - | - |
| 210802 | Аудитын төлбөр | 3,000,000.00 | 21,400,000.00 | 18,400,000.00 | 713.3 |
| 210808 | Банк,санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 58,379,412.50 | - | |
| 210810 | Гадаад, дотоодын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл | 11,700,000.00 | -- | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210811 | Элсэлт төгсөлттэй холбоотой зардал | 1,979,036.40 | - | - | - |
| 210814 | Бусад төлбөр хураамж татвар | 5,710,000.00 | 4,965,350.00 | (744,650.00) | 86.9 |
| 210815 | Багш ажилтны эрдэм шинжилгээ, судалгаа | 5,200,160.00 | - | - | - |
| 210817 | Найрамдал Европын холбоо төсөл | - | 4,689,350.00 | - | - |
| 210818 | TACMEE төсөл | - | 276,000.00 | - | - |
| 210819 | Төсөл хөтөлбөрийн зарцуулалт | - | 56,954,192.00 | - | - |
| 210820 | EX-Digital movie-төсөл | - | - | - | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **833,383,278.00** | **65,711,410.00** | **(767,671,868.00)** | **7.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 8,255,119.00 | - | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 26,916,209.00 | 56,461,591.00 | 29,545,382.02 | 209.8 |
| 210905 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 3,600,000.00 | - | - | - |
| 210907 | Оюутны спорт, урлагын арга хэмжээ | 2,399,969.00 | -- | - | |
| 210909 | Мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар | 467,100.00 | - | - | - |
| 210911 | Төлөвлөгөөт арга хэмжээ | 800,000,000.00 | 994,700.00 | (799,005,300.00) | |
| **211** | **ХҮҮ** | **2,000,000.00** | - | - | - |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 2,000,000.00 | - | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,844,000.00** | **12,414,154.73** | **(7,429,845.27)** | **62.6** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **7,500,000.00** | **12,414,154.73** | **4,914,154.73** | **165.5** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 9,544,000.00 | 1,944,654.73 | (7,599,345.27) | 20.4 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,800,000.00 | 10,469,500.00 | 7,669,500.00 | 373.9 |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **4,578,866,850.00** | **4,638,446,245.88** | **57,866,544.44** | **101.3** |
| **1200041** | **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** | **2,451,866,850.00** | **2,315,150,566.52** | **(136,716,283.48)** | **94.4** |
| 12000411 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 2,451,866,850.00 | 2,315,150,566.52 | **(136,716,283.48)** | **94.4** |
| **1200042** | **ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** | **127,000,000.00** | **185,859,451.44** | **57,146,600.00** | **145.0** |
| 12000421 | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 127,000,000.00 | 185,859,451.44 | **57,146,600.00** | **145.0** |
| **1200043** | **ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ОРЛОГО** | **2,000,000,000.00** | **1,565,093,127.92** | **(434,906,900.00)** | **78.3** |
| | Төсөл, хөтөлбөрийн орлого | 2,000,000,000.00 | **1,565,093,127.92** | **(434,906,872.08)** | **78.3** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | - | **572,343,100.00** | - | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 572,343,100.00 | - | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 572,343,100.00 | - | - |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | - | **498,602,480.09** | - | - |
| **3101** | **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | - | **883,416,844.97** | - | - |
| | **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТ** | - | **384,814,364.04** | - | - |
| | Байгууллагын тоо | 1 | 1 | - | - |
| | Ажиллагсдын тоо | 75 | 70 | (5) | 93.33 |
| | Удирдах ажилтан | 1 | 1 | - | - |
| | Гүйцэтгэх ажилтан | 74 | 69 | (5) | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ХААИС-ийн харьяа Дархан салбар сургууль нь сургалтын орчныг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх эрхэм зорилго дэвшүүлж, их сургуулийн орчныг иж бүрнээр хөгжүүлэх хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж, багш оюутнуудын ажиллах, суралцах, амьдрах таатай орчныг бүрдүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг сайжруулах, элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээ, инновацын хамрах хүрээг өргөжүүлэх, санхүүгийн тогтвортой, бие даасан байдлыг хангаж, санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Боловсролын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолоор баталсан “Их дээд сургуулийг сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХААИС-ийн харьяа Дархан салбар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ХААИС-ийн харьяа Дархан салбар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 966,087.0 мянган төгрөгөөр буюу 12 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 498,602.5 | 883,416.8 | 384,814.3 |
| Авлага | 20,870.4 | 338,256.5 | 317,386.1 |
| Урьдчилгаа | 796,210.1 | 1,208,529.9 | 412,319.8 |
| Бараа материал | 189,771.5 | 225,943.3 | 36,171.8 |
| Үндсэн хөрөнгө | 6,149,733.3 | 5,965,128.2 | (184,605.1) |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,393,789.6) | (1,730,034.8) | (336,245.2) |
| **Нийт хөрөнгө** | **7,655,187.9** | **8,621,274.9** | **966,087.0** |
| Нийт өр төлбөр | 496,892.7 | 818,982.0 | 322,089.3 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 7,158,295.2 | 7,802,292.9 | 643,997.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **7,655,187.9** | **8,621,274.9** | **966,087.0** |

Мөнгөн хөрөнгийн 883,416.8 мянган төгрөгийн үлдэгдэл нь "Найрамдал төсөл хөтөлбөр"-ийн санхүүжилтийн үлдэгдэл байна.

Тайлант оны эцсийн авлагын үлдэгдэл нь томилолтын урьдчилгаа олгосноос үүссэн зөрүү 50,249.3 мянган төгрөг, оюутны дотуур байрны төлбөр 16,904.9 мянган төгрөг, байгууллагаас авах 271,102.3 мянган төгрөгийн авлага байна.

Урьдчилгаа данс 412,319.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Хонгор сумын Зулзагын гол багт нарс модны үржүүлгийн байр барихад 101,578.2 мянган төгрөг, "Найрамдал төсөл, хөтөлбөр"-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдэд 1,106,951.8 мянган төгрөгийг урьдчилан төлснөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,171.8 мянган төгрөгөөр өсөхөд "Найрамдал төсөл, хөтөлбөр"-ийн санхүүжилтээр 170,200.0 мянга, өөрийн хөрөнгөөр 209,578.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, төв сургуулиас 824,895.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, 1,158,691.4 мянган төгрөгийн материалыг зарцуулж, 9,810.4 мянган төгрөгийн материал акталсан нь нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдлийн 96 хувийг хангамжийн материал эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд 56,954.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив болон төслийн хөрөнгөөр ирсэн 94,685.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, 336,245.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан байна.

Нийт өр төлбөр дансны үлдэгдэлд цалингийн өглөг 292.0 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 2,356.3 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 15,589.9 мянган төгрөг, ҮЭ-ийн хорооны өглөг 1,181.9 мянган төгрөг, байгууллага, хувь хүнд өгөх өглөг 5,788.5 мянган төгрөг, төсөл хөтөлбөрийн урьдчилан орж ирсэн орлого 793,773.4 мянган төгрөг бүртгэгдсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны зардлын төсвийн төсөлд нийт зарлагыг 4,096,322.6 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг сургалтын төлбөр, төсөл хөтөлбөр, түрээсийн орлогоос 4,096,322.6 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч зардлын төсвийн саналыг хэвээр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд зардлыг санхүүжүүлэхээр сургалтын төлбөрийн орлогоос 2,451,866.8 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 127,000.0 мянган төгрөг, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээс орох орлого 2,000,000.0 мянган төгрөг, нийт 4,578,866.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр сургалтын төлбөрийн орлогоос 2,315,150.6 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 32,641.5 мянган төгрөг, Боловсролын зээлийн сангаас 572,343.1 мянган төгрөг, төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээр 1,565,093.1 мянган төгрөг, хандив, тусламжаар 151,505.1 мянган төгрөг, валютын ханшийн зөрүү ашиг 1,712.8 мянган төгрөг, нийт 4,638,446.2 мянган төгрөгийн орлого төвлөрч, урсгал үйл ажиллагаанд 4,139,193.2 мянга, үндсэн хөрөнгө худалдан авахад 56,954.2 мянган төгрөг, санхүүгийн үйл ажиллагааны зардалд 55,771.6 мянган төгрөг, нийт 4,253,631.8 мянган төгрөг зарцуулснаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 384,814.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,253,631.8 мянган төгрөг буюу 103.8 хувьтай байгаа нь үндсэн бус үйл ажиллагааны орлогын биелэлт 145 хувиар нэмэгдэж, орлогыг сургалтын үйл ажиллагаанд зарцуулснаас голлон шалтгаалжээ.

Тус байгууллага нь 100 хувь өөрийн орлогоос санхүүждэг тул төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ байхгүй болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу ХААИС-ийн харьяа Дархан салбар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагаа, Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөвлөмж өгснийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Ч.Гантулга гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

ХААИС-ийн харьяа Дархан салбар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 0117/25 тоот албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны зардлын төсөв 4,096,322.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 40,963.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд байр ашиглалтын зардлыг 6,491.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 18,898.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 6,763.0 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 14,241.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 25,520.5 мянган төгрөгийн 2 мэдээллийг оруулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дэх заалттай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим нэгдсэн хуудаст байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Ахмад настны тухай хууль 2017 онд батлагдан мөрдөгдөж эхэлсэн. Уг хуулиар ахмад настнуудад нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх зориулалттай ахмадын санг байгуулаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:*

Ахмад настны тухай хууль 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуй нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах, зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан ба 900.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн бөгөөд ТШЗ-ийн 2024 оны 05 дугаар сарын 31-ны 01 тоот албан бичгээр ирүүлсэн биелэлтийг шалгахад 100 хувь хэрэгжсэн байна.

*Хүснэгт 2 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 900.0 | 1 | 900.0 | 100.0 |
| **Нийт дүн** | **1** | **900.0** | 1 | **900.0** | 100.0 |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд[1] 2 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа, зөрчил илрээгүй болно.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай

*Илрүүлэлт*:

Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим системийг эрчимжүүлэх able, docx.mn албан бичиг солилцооны программыг тус байгууллага нэвтрүүлэн ашиглаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоолоор баталсан "Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай", Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалаар заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

Тайлангийн 4.4.1, 4.4.2 дахь хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хууль, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

[2] .Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ахмадын сан байгуулаагүй | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим системийг эрчимжүүлэх able, DOCX программыг ашиглаагүй | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | -- | - |
| **Дүн** | **2** | - | - | - | - | - | **2** | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2 мэдээллийг оруулаагүй байна. | 1 | **25,520.5** | - | - | - | - | 1 | 25,520.5 |
| **Дүн** | **1** | **25,520.5** | - | - | - | - | **1** | **25,520.5** |